

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батсүх	Дугаар	L180
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэ
Төрсөн газар	Эрдэнэ сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Засаг даргын Тамгын газрын дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сангийн далайн хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАЭР 099
Одоогийн сүм хийд	Сангийн далайн хийд	Сүм хийдийн дугаар	ГАЭР 003
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Сангийн далайн хүрээ

2007 оны 8-р сарын 23-ны өдөр. Судалгааны баг Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын дарга Батсүх гуайтай уулзаад байна.

Асуулт:-Та энэ сумын нутагт байсан Сангийн далайн хүрээний түүхийг ярьж өгнө үү.

Хариулт:-Сангийн далай хийд бол Ёст бэйсийн хошуу гэж байсны гол хийд байсан байгаа юм. Засагт хан аймгийн Ёст бэйсийн хошуу гэдэгт одоогийн Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Баянцагаан сумын зарим хэсэг, Эрдэнэ сум, Чандмань сумын зарим хэсэг хамаарч байсан ийм томоохон хошуу байсан юм байна лээ. Сангийн далай хийд нилээн эртний байгуулагдсан түүхтэй. Түүхийн нарийн баримтууд бүгд хэлмэгдүүлэлтийн үед устаж үгүй болсон. Хадгалж хамгаалсан юм багатай, түүхэн талаасаа тийм юм билээ. Ард иргэдийн яриагаар энэ их олон лам хурдаг. Маанийн үрэл дэвэрч байсан ийм том хийд гэж ярьдаг. Энэ талаасаа авч үзэх юм бол нэлээн эртний бас олон чадалтай лам бүхий ийм томоохон хийд байсан гэдэг нь ойлгогдож байдаг. Ингээд хийдийг хэлмэгдүүлэлтийн үед лам хуврагуудаас эндээс нэлээн олон лам хуврагууд хэлмэгдэж, баригдаж явсан байдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэрнээс амь хэлтэрсэн хоёр гурван лам байсан юм билээ. Тэдгээр нь насны эрхээр нэлээн эртхэн өөд болцгоосон ийм байгаа.

Ингээд 30, 40 жил энэ хийд ажиллагаагүй байж байгаад 1993 оноос эхлээд сүм хийдийг сэргээх ажил ард олны итгэл сэтгэлийн үүднээс эхэлж явсаар байгаад 2000 онд одоогийн шинэ төв дээр хийдийн барилга барьсан.

Орон нутагт жинхэнэ шашны сургууль төгсөөд ирсэн лам **хуварга** гэж байдаггүй. Өөрсдийнхөө **авъяасаар** жаахан тийм шашны талын ном уншдаг, ийм л ганц нэг хүмүүс байдаг. Энэ дээр Балжинням гэж 40-өөд насны залуу бий. Тэр энэ хийдийг хариуцаад байж байгаа.

Бид шинээр хийд байгуулсантай холбогдуулаад Өвөрхангай аймгийн Хархорин дахь шашны коллежид нэг хүүхэд явуулаад сургасан юм. Тэр маань төгсөөд ирсэн ч гэсэн бас энэ сүм хийд дээр тогтвортой байхгүй, цэргийн албанд яваад өнгөрсөн хавар халагдаж ирсэн байгаа. Одоо байнгын ажиллагаа байхгүй, хааяа нэг хурал хурдаг сарын шинийн 3, 15 ч гэдэг юмуу ийм өдрүүдэд сүсэгтэн олон цуглаж, лам нь сан сангаа тавьж ингэдэг. Өдөр тутмын уншлага, үйл ажиллагаа гэж байхгүй ийм байж байгаа.

Түүхийн нарийн нандин хадгалсан юм маш их ховор. Ард түмний яриагаар бол эндээс хэлмэгдсэн лам нарыг аваад зарим юмыг нь ачиж бариад явж байсан. Ингээд тэнд гол шүтээн бүхий ачаатай **тэмээ** нь улсууд яриагаар зориудын хэлбэрээр алдуурч буцааж ирсэн. Тэгээд **энд хаа** нэгэн газар тэрнийг нуусан байх **ёстой** гэдэг. Тэрнийг энд нуусан, тийм гээд нотлох баримт байдаггүй, мэдэх хүн байдаггүй учраас эрж хайх бололцоо байдаггүй.

Мөн зарим хүмүүсийн ярьж байгаагаар нэлээд тийм гуулин **бурханыг** хуучин хийдийн түүрийн хажууд нуур бий л дээ. Тэр нуурын ус руу хийсэн ч гэж ярьдаг л юм, энэ дээд уулын аманд аваачиж хаяж устгаж, шатааж хэмхэлсэн юм гэсэн яриа хөөрөө ч байдаг л юм. Одоо **ингээд яваад** үзэхээр зэрэг нуурын усан дотор орж үзсэн биш, хэн **мэдэхэв** ямар юм байдаг юм мэдэхгүй. Уулын амаар нь энд тэгж байсан гэж мэдэгдэх юм байдаггүй, ийм л юм байдаг. Хийдийн их хамба ийм хүн байсан гэдэг тэрний хөрөг олдсон. Энэ хөргийг нь бас томоохон хэмжээний, гарын уртай урлагийн сургууль төгссөн хүнээр хийлгэсэн юм хийдэд залаатай бий.

Бид нар 2000 онд энд шинээр хийдийн барилга бариад Өвөрхангай аймгийн Хархорины тэр хийдийн хамба эд нарыг 20-иод лам урьж энд ном уншуулж хуруулсан л даа. Тэд нар дотор нь бага сага тийм шашны эд өлгийн зүйлүүд өгсөн. Тэр нь тавиатай бий. Мөн сүсэгтэн олон **өөрсөддөө** хадгалагдаж байсан ном судар, ганц хоёр юм өгсөн ийм юмнууд бий. Ингээд дотор нь орох юм бол хийд маань бас зохих хэмжээний хийд байна гэдэг нь харагдахаар байгаа боловч байнгын үйл ажиллагаагүй ийм л хэлбэртэй байгаа л даа. Энэнээс өөр надад нарийн мэдэх юм байхгүй. Уулаасаа ч би энэ сумын уугуул иргэн биш учраас бас юмыг нарийн сайн мэдэхгүй ийм хүн байгаа юм.

Асуулт:-1937 оны хэлмэгдүүлэлтээс өмнө Сангийн далай хүрээний хамба лам хэн гэдэг нэртэй хүн байсан бол?

Хариулт:-Нэрийг нь сайн мэдэхгүй юмаа, энэ улсууд их хамба л гэж ярьдаг юм билээ. Их, бага хамба гэж хоёр тийм том лам байсан юм шиг байгаа юм. Тэгээд 2, 3 зуун ламтай, их том хийд байсан гэж яригддаг юм шүү дээ.

Асуулт:-Хийдийн лам нар уул овоогоо тахидаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тахидаг байсан гэж байгаа. Манайд үе уламжлаад тахиад ирсэн Эрдэнэ Овоо гэж том юу байна, Төгс овоо гэж бас байна. Энэ хоёрыг л лав тахиж байсан байдаг. Сүүлийн үед Балжинням гэж одоо энэ хийд хариуцаж байгаа залуу бол энэ хоёр овооны тус тусынх нь тахидаг ном судрыг хайгаад заримыг нь олж байгаа гэж ярьдаг юм билээ. Бид төвд ном мэдэхгүй учраас энэ байна гээд юу ч харуулсан тийм байжээ гэхээс өөр юмгүй улсууд чинь тэрнийг нарийн мэдэх ч юм алга. Тэгээд төрийн захиргааны ажилтан болохоор шашны юм руу анхаарч, хутгалдах боломж байдаггүй.

Харин нутгийн өөрөө удирдах байгууллагын энэний түрүүчийн хурлын дарга эд нар бол энийг нэлээн хөөцөлддөг байсан. Одоогийн хурлын дарга энэ дээр их сайн хөөцөлдөж чадахгүй байх шиг байна. Бас шинэ тутам болоод энэ чинь жил гаруй, 2 жил болж байгаа юу, хурлын даргаар сонгогдоод. Тэгээд энэ хугацаанд бас...

Асуулт:-Барилгыг нь юугаар барьсан байсан бол?

Хариулт:-Одоогийн энэ барьсан барилгыг модоор барьсан.

Асуулт:-Дээр үед байсан?

Хариулт:-Дээр үеийнх нь эртний өвгөчүүлийн **ярьдгаар** жан тоосго гэж ярьдаг юм байна лээ. Саяхан болтол нэг дуган нь байсан юм. Бүтнээрээ. Бөмбөгөр оройтой. Гаднаас нь харахаар шавар юм байсан, дор нь модоор хийгээд, модыг нь шавардсан ийм л юм байсан юм билээ. **Тэгээд тэр** нь олон жилийн нар, бороонд элэгдэж явсаар байгаад 1993 онд байна уу даа, нэг **хавар өөрөө** уначихсан юм. Хүмүүсийн ярих нь нэг л оньс байдаг, тэрнийг мулталбал бүгд задрахаар ийм л нарийн хийцтэй юм гэж ярьдаг байсан, хөгшчүүл.

Асуулт:-Монголчууд өөрсдөө барьсан юмуу?

Хариулт:-Монгол дархан мужааны үр ухаан гэж ярьдаг байсан.

Асуулт:-Хийдийн гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Улаан сахиус гээч юм зарим нь ярьдаг. Хэд хэдэн ондоо яригдаад байдаг юм. Бид нар яг ямар юм байсныг би лав тодорхой мэддэггүй. Нэлээд хэсэг хүмүүсийн ярих нь улаан сахиус гэж гол шүтээн нь тийм байсан гэж ярьдаг. Нэг хэсэг нь арай өөр юм ярьдаг юм билээ.

Асуулт:-Улаан сахиус гэдэг чинь Жамсран бурхан уу?

Хариулт:-Тийм л юм байдаг байх. Өөр надад мэдэх юм байхгүй.

Асуулт:-Ямар хүн анх байгуулж байсан гэж үздэг юм бол?

Хариулт:-Анх энэ хийдийн үүсэхийн нь үү? тэрнийг нь мэдэхгүй. Одоогийн энэ хийд барилгыг шинэчилж үүсэхэд нь Баянзул гээд энэ Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын харьяат нэг лам залуу үүсгэн байгуулалцсан юм. Тэгээд тэр залуу лам өөрөө бурхан болчихсон л доо.